# *Ариун тангарагийн эзэд*

Миний гэр бүлийн хүн амаржихаар саяхан аймгийн нэгдсэн больницын төрөх тасагт очоод 10 цаг гаруй өвдөөд амаржиж чадахгүй байлаа.

Тэр өдрийн дежурын их эмч, эх баригч, сувилагч нар хэвийн байдлаар амаржуулахын тулд бололцоотой бүх арга хэмжээ авсан боловч амаржиж чадсангүй.

Гэтэл зэлдэг зантай, эгчмэд насны нэгэн эмч намайг дуудаж уулзаад «За хүү минь! Гэр бүлийн чинь хүний энэ төрөлт жирийн төрөлт биш байна.

Ихэр хүүхэд бие биеэндээ тээглээд гарч чадахгүй байна.

Иймд бид мэс заслалын аргаар хүүхдий нь авъя гэж шийдлээ.

Айх юмгүй эхэд нь ямар ч аюулгүй. Ингэхгүй бол хүүхдүүдийг нь амьд авч чадахгүй» гэлээ.

Миний сэтгэлд элдвийн зүйл эргэлдэн бодогдож бидний амьдралд золгүй явдал тохиолдох нь үү дээ гэж санагдсан боловч шинжлэх ухааны өргөн мэдлэг туршлага бүхий их эмч нар, эмнэлгийн ажилтнууд, орчин үеийн техник төхөөрөмжөөр тоноглогдсон эмчилгээний газар байгаа болохоор бидний амьдралд үхэл өнчрөл гашуун зовлон учрахгүй гэдэг бодол миний сэтгэлийн хямралдааныг арилган тайтгаруулж байв.

Ингээд их эмч Дуламжав, Нямдаваа, Г Алтангэрэл нар мэс заслал хийлээ.

25 минутын дараа хоёр хүүхдийг сувилагч нар тэврээд нялхсын өрөө рүү гүйлдлээ.

Ахиад 20-иод минутын дараа эмч нар болон бусад хүмүүс мэс заслалийн өрөөнөөс ер бусын баяр баясгалантай гараад ирлээ.

«...За! одоо айх юмгүй. Гэр бүл хүүхдүүд чинь бүгд сайн боллоо. Харин эхий нь асарч тэнхрүүлэх нь чухал. Хүүхдүүд чинь зүгээр» гэлээ.

Миний болон хамт сэтгэл шимшрэн хүлээж суусан нөхдийн сэтгэлд баяр баясалын наран мандав.

Ингэж эдгээр эмч сувилагч нар дөчөөдхөн минутын дотор 3 хүний амь насыг үхлийн аюулаас аварсан юм.

Одоо миний ихэр хоёр охин эрүүл энх бойжиж эхий нь бие сайн эдгэрч байна.

Хүн ардынхаа эрүүл энхийн төлөө бүх хүч, оюун мэдлэгээ дайчилж эрхэм сайхан тангарагаа үнэнчээр биелүүлж яваа манай өнөөгийн шилдэг хүмүүс, ирээдүйн хүний үлгэр дууриал болсон их эмч Дуламжав, Нямдаваа, Г.Алтангэрэл, сувилагч Норов, Цэрэнням, Цэнд, Мөнх-Өнөр, эх баригч Хорлоо. Ягаан болон нэгдсэн больницын хамт олонд чин сэтгэлийн халуун талархлаа дэвшүүлж цаашдын ажил үйлсэд чинь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

*Аймгийн АДХГЗахиргааны*
*ажилтан Огтбиш*

# Техник засварыг цагт нь чанартай дуусгая

1965 оны улс, ардын аж ахуйн төлөвлөгөөт зорилтын биелэлтэнд хаврын тариалалтын ажил чухал үүрэг гүйцэтгэх юм.

Энэ онд манай хөдөө аж ахуйн нэгдлүүд нийтдээ 18,5 мянган га талбайд үр тариа, малын тэжээл, төмс төрөл бүрийн хүнсний ногоо тариалж 15,6 мянган тонн үр тариа, 1,5 мянган тонн төмс, хүнсний ногоо хураан авах бөгөөд энэ нь тариалангийн талбайг 6,8 хувиар өрөгжүүлж, хураан авах үр тарианы ургац 24,3, төмс, хүнсний ногооны ургац 152,9 хувиар нэмэгдэх гэсэн үг юм.

1965 оны тариалангийн ажил эхлэх цаг аажим аажмаар ойртсоор байгаа нь төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхийн тул хаврын тариалалтад ягштал төхөөрөн бэлтгэхийг яаруулж байна.

Одоогийн байдлаар манай аль ч станцад төлөвлөгөө ёсоор засагдвал зохих техник бүрэн засагдаагүй байна.

Энэ нь төв орон нутгийн байгууллагаас засварын явцад тавих хяналт шалгалт сул, засварыг гардан хийж байгаа засварчид болон түүнийг удирдан хийлгэж буй хүмүүсийн ажлын хариуцлага муу байгаагаас шалтгаалж байна.

Жил бүрийн хаврын тариалалтын техник засварын ажлыг 3 сарын 1—ны наана дуусгадаг журамтай болохыг МАХН—ын Төв Хорооны 1963 оны 4 дүгээр бүгд хурал чухалчлан заасан билээ. Одоо уг хугацаа дуусаад 50 хүрэхгүй хоног үлдээд байна.

Иим учраас манай сангийн аж ахуй, мал аж ахуйн машинт станц бүр техник засварын ажлын графикийг хатуу баримтлан мөрдөж инженер механикчид нарын ажлын хариуцлагыг дээшлүүлэн, засварын ажлыг яаравчлан дуусгах арга хэмжээг авах хэрэгтэй байна. Энэ ажилд уралдааны олон хэлбэрийг ашиглах хөдөлмөрийн бүтээмж, ажлын чанарыг дээшлүүлэх аливаа санаачлагыг дэмжин дэлгэрүүлбэл зохино.

Засварын ажилд орчин үеийн тэргүүний практик арга болох агрегатчилсан системийг хэсэг бүхэнд нэвтрүүлж түүнд ажиллаж байгаа хүмүүсийг тогтмол ажиллуулах хэрэгтэй байна.

Засвараас гарч байгаа техник нэг бүрийг нарийн чанд хүлээн авах, зохих хугацааны зүгшрүүлэлт хийх, агрегат бүхнийг хянах стен дээр шалгаж байх зэрэг нь засварын чанарыг эрс дээшлүүлэх үндэс болно.

Мөн төвийн паркын засварын ажилд оролцоогүй трактор комбайнчдыг тракторын хээрийн бригадуудтай багаж хэрэгсэл аж ахуйн зүйлсээр ханган гаргаж хөдөө аж ахуйн чиргүүл техникийн засварт оруулах нь зүйтэй байна.

МАХН—ын Төв Хорооны 4 дүгээр бүгд хурлын заалтыг хугацаанд нь биелүүлэхэд манай сангийн аж ахуй, мал аж ахуйн машинт станцууд өөрийн ажлын голыг чиглүүлж, засварын ажлыг хугацаанд нь чанар сайтай дуусгах явдал одоо даруй шаардагдаж байна.

*Инженер* Т.*Батсүх*

*Идэвхтэн бичигчдэд тусламж*

# Өгүүлэл бичих тухай

(*Үргэлжлэл түрүүч нь № 4-т*)

## 2. СУРТАЛЧЛАХ ӨГҮҮЛЭЛ

Үүний чиглэл нь Марксист-Ленинист онолын чухал үндэслэл, намын бодлого, түүний баатарлаг түүх, ард түмний түүх, эх оронч үзэл, пролетарийн интернационалист үзэл, социалистөс суртахуун шинжлэх ухаан, техникийн шинэ шинэ үндэслэл зэрэг бусад зүйлийг тайлбарлан таниулах явдал юм. Сурталчлах өгүүлэлд Марксист онолыг социалист, коммунист байгууллалтын практик ажиллагаатай нягт холбохгүй бол тэр нь зорилгоо үнэ цэнтэй дүүрэн хангаж чадахгүй юм.

Практикаас аль нэг хэлбэрээр тасарвал хоосон сургаал болох билээ.

Онол, практикийн нягт холбоо нь сурталчлагыг тухайн зорилго эрмэлзлэлд яг нийцсэн амьдралын хүч нөлөөтэй болгодог.

Социалист сонин хэвлэлийн сурталчлага нь дайчин давшилттай шинж чанарыг хадгална.

Сурталчлах өгүүлэл нь манай цаашдын хөгжил урагшлах хөдөлгөөнд саад тотгор бологч нэгэнт үеэ өнгөрөөсөн бүх үзэл заншлын эсрэг шийдвэртэй тэмцэж, Марксизмын эсрэг үзэл, хөрөнгөтний үзэл суртлын элдэв илрэлийг хайр найргүй илрүүлдэг юм.

Сурталчлах өгүүлэлийн гол онцлог гэвэл; Нам төрийн удирдамж, заалгууд эсхүл шинжлэх ухаан техникийн, уран санааны ололтуудыг онолын гүн гүнзгий үндэслэлтэйгээр задлан дүгнэж тайлбарлан таниулж сурталчилхад оршино.

(*Үргэлжлэл бий*)



*ЗУРАГ ДЭЭР; Зүүн гар талд их эмч Дуламжав, баруун гар талд ихэр 2 хүүхэд эхийн хамт*

# МАЛ ЭМЧИЛГЭЭНИЙ

Манай нам засгаас мал сүргийг өсгөн үржүүлж түүнээс авах ашиг шимийг нэмэгдүүлж үүлдэр угсааг сайжруулах талаар зүйл бүрийн арга хэмжээг авсаар ирсний дотор мал эмнэлгийн байгууллагыг бэхжүүлэх ба түүний мэрэгжилтэй боловсон хүчнийг олшруулах, малын элдэв халдварт, халдваргүй өвчинтэй тэмцэх ажлыг улам эрчимтэй зохиож ирсний ачаар манай оронд мал сүргийг олноор өвчлүүлэн хорогдуулж байсан мялзан, годрон зэрэг гоц халдварт өвчнийг бүрэн устгаж. боом, дуут, цэцэг зэрэг ихээр гарч байсан өвчин эрс багасаж эмчлэн эдгэрүүлэх ажил ихээхэн амжилтанд хүрч байна.

Тус аймагт 1964 онд халдваргүй өвчнөөр 44135 толгой мал өвчилсний 74,5 хувийг нь халдварт ба паразит цагаан хорхойн өвчнөөр 44532 мал өвчилсний 83,8 хувийн нь тус тус эдгэрүүлсэн юм. Эдгээр өвчилсөн бүх малыг хамгийн хямд үнэтэй хонь ямаа өвчилсөн юм гэж үзээд түүнийг дансны үнээр үнэлж үзвэл 2837344 төгрөгний үнэ бүхий малыг эмчлэн эдгэрүүлж ард түмнийхээ аж байдлыг сайжруулах үйлст малын эмч нар зохих хувь нэмрээ оруулжээ.

Энэ ажилд идэвхтэй ажиллаcан тэргүүний эмч нараас дурьдвал Баянцагаан сумын малын их эмч Урган, Алтанбулгийн груп пын их эмч Нямаа, Эрдэнэ сумын их эмч Ёндон, Баяндэлгэр сумын их эмч Намсрай, Мөнгөн морьтын бага эмч Банзрагч, Баянцагаан сумын бага эмч Жамсран Баянжаргалан сумын бага эмч Улам-Орших, Сэргэлэн сумын бага эмч Самбуу, Баянзүрх сумын санитарч Лувсандулам нарын зэрэг мал эмчлэх ажлаараа тэргүүн байранд яваа олон сайчуул байна.

Гэтэл 1964 онд Лүн суманд өвчний шалтгаанаар мал тун их хорогдсон билээ.

Нийгмийн ийм их хөрөнгө үрэгдэж байхад тэнд ажиллаж байсан малын эмч, нам, улсын хариуцлагатан нөхөд оновчтой арга хэмжээ авч тооцоолж үзээгүй нь тун их харамсалтай бөгөөд олиггүй явдал юм.

Нөгөө талаар тус суманд мал аж ахуйд хандах хандлага сул арчилгаа маллагаа нь тун дорой байсан нь өвчтэй мал эмчилгээ муу авах нөхцөл болж өгсөн нь дамжиггүй юм.

Одоо энэ суманд хамуу өвчтэй 154 мал, сэжигтэй 8500 мал байгаа нь аймгийн хэмжээнд хамуу өвчний талаар дээгүүр суурьнд орсон хэвээр байна.

